



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 4/15

Жаргалтхаан сум

**Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ
хийх комисс томилох тухай**

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3 дахь заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалт, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Сайдын 2020 оны 06-р сарын 02-ны өдрийн А/280 дугаар тушаалын хавсралт, “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын ахлагч: Д.Бямбадорж – сургалтын менежер

Гишүүд: С.Наранцэцэг - бага ангийн багш

Л.Дархисүрэн – бага ангийн багш

Д.Алтангэрэл - дуу хөгжмийн багш

Б.Амгаланбаяр - биеийн тамирын багш

Б.Батзориг - биеийн тамирын багш

Т.Энхнаран - цэцэрлэгийн арга зүйч

2. Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээг журам, шалгуурын дагуу зохион явуулж, үр дүнг хугацаанд нь системд шивж, танилцуулж ажиллахыг комиссын дарга (Д.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Д.ЧИНБАТ

D/Tushaal-2025

20250922